

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэн стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагч: Аймгийн Засаг дарга

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2024.04.01	A/136	Дэмжлэг үзүүлэх тухай	
2	Аймгийн Засаг дарга	2024.04.01	A/137	Дэмжлэг үзүүлэх тухай	
3	Аймгийн Засаг дарга	2024.04.04	A/149	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2024.04.05	A/152	Хөрөнгө зарцуулах тухай	
5	Аймгийн Засаг дарга	2024.04.05	A/154	Хөрөнгө зарцуулах тухай	
6	Аймгийн Засаг дарга	2024.04.09	A/165	Хөрөнгө зарцуулах тухай	
7	Аймгийн Засаг дарга	2024.04.10	A/167	Төсөв зарцуулах тухай	
8	Аймгийн Засаг дарга	2024.04.15	A/171	Хөрөнгө зарцуулах тухай	
9	Аймгийн Засаг дарга	2024.04.15	A/172	Дэмжлэг үзүүлэх тухай	
10	Аймгийн Засаг дарга	2024.04.15	A/173	Дэмжлэг үзүүлэх тухай	
11	Аймгийн Засаг дарга	2024.04.17	A/180	Дэмжлэг үзүүлэх тухай	
12	Аймгийн Засаг дарга	2024.04.22	A/187	Дэмжлэг үзүүлэх тухай	
13	Аймгийн Засаг дарга	2024.04.24	A/192	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/136

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Б.Долгорсүрэн, Ч.Дашдондов нарт тус бүр 500,000 (Таван зуун мянга) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн "Аутизмтай хүүхдийн зан үйл засал, тэдний бие даах чадварыг дэмжих арга зүй" сэдэвт сургалтын Улаанбаатар хотоос ирэх багш нарын шатахууны зардалд зарцуулах 1,600,000 (Нэг сая зургаан зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 2,600,000 (Хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



671010429



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/137

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Титэм” Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Э.Энх-Үжин нь АНУ-ын Нью-Йорк хотод зохион байгуулагдах олон Улсын хөгжмийн наадмын Гала тоглолтод оролцох зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөг, Жүдо бөхийн “Хоймор нутаг” холбооны баг тамирчид Өвөрхангай аймгийн Хар хорин суманд зохион байгуулагдах Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 1,600,000 (Нэг сая зургаан зуун мянга) төгрөг, Рашаант сумын уугуул Т.Цагаач нь Монгол Улсын гавьяат механикжуулагч цолоор шагнагдсанд хүндэтгэл үзүүлж 2,000,000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 5,600,000 (Таван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн) -т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671:010414



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/149

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн албанд татагдан алба хааж байгаа дайчдын албан үүргээ гүйцэтгэх, ая тухтай амьдах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс хувийн эд зүйл хадгалах төмөр шкаф худалдан авах зардалд 3,030,000 (гурван сая гучин мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх 3,030,000 (гурван сая гучин мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын эрх зүй, нийгмийн хэв журам хөтөлбөрт тусгагдсан Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010449



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/152

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн улаан буудайнаас Хөвсгөл аймагт хуваарилагдсан 200 тн, улаан буудайг савлахтай холбоотой зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлын 6,660,000 (Зургаан сая зургаан зуун жаран мянга) төгрөгийн зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



6712010460



Аймгийн Засаг даргын 2
04 дугаар сарын 05-ны өдрийн /05/ дугаар
захирамжийн хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ЗАРДЛААС
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт өртөг
1	Шуудай	5600	450	2520000
2	Уутны ам боох чансаа	4	35000	140000
3	Ажиллах хүмүүсийн хоолны зардал	200	20000	4000000
	Нийт			6.660.000

-----oOo-----



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/154

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотой зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх ажилд зориулж сумдад хуваарилах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай

2. Дээрх зардлын 40,000,000 (Дөчин сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671010468

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 05 өдрийн А/И/У захирал



1 дүгээр хавсралт

МАЛ АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАХ, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛ
ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	Сумын нэр	Малын тоо	Зүй бусаар хорогдсон малын тоо	Устгалын цэгийн тоо	Зарцуулах мөнгөн дүн / сая /
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс					
1	Улаан-Уул	221678	15612	6	4,0
2	Баянзүрх	307094	14455	3	4,0
3	Мөрөн	239909	11024	1	3,0
4	Арбулаг	410352	12323	4	3,0
5	Их-Уул	309362	6285	3	3,0
6	Түнэл	301355	6617	2	3,0
7	Тосонцэнгэл	336919	4879	1	3,0
8	Рашаант	237037	5157	2	3,0
9	Тариалан	253585	3497	3	3,0
10	Ренчинлхүмбэ	193384	2753	3	3,0
11	Алаг-Эрдэнэ	216149	1920	2	2,0
12	Эрдэнэбулган	102595	1326	1	2,0
13	Ханх	61744	787	1	1
14	Чандмань-Өндөр	61598	418	2	1
15	Цагааннуур	26225	264	2	1
16	Цагаан-Үүр	33071	110	1	1
	Нийт	3312057	87427	37	40,0

оОо



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/165


Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10, 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн 100 тн тэжээлийн будаа (овьёос) Сэлэнгэ аймгаас татан авах тээврийн зардал, цаг агаар дулаарч шар усны үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд зориулж сумдад олгох хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.
- 2.Тэжээлийн будаа татах тээврийн зардал, шар усны үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зардалд шаардагдах нийт 25,000,000 (Хорин таван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.
- 3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671 2010500



Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дугаар сарын 09-ны өдрийн 04 дугаар
захирамжийн хавсралт



НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Тээврийн зардал	Сэлэнгэ аймгаас тэжээлийн будаа татах зардал	12,000,000
2	Баянзүрх сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,000,000
3	Рэнчинлхүмбэ сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,000,000
4	Галт сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,500,000
5	Цэцэрлэг сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,500,000
	Бүгд		25,000,000

-----oOo-----

6.988.0014



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/107

Мөрөн сум

Төсөв зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ний А/682 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон сумдын санхүүгийн албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүдийг шинэ мэдээ мэдээллээр хангах, чадавхжуулах, туршлага судлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад 10,000,000 (Арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын санхүүжилт 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын "Эрх зүй, нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах зардал"-с гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6713010509



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/171

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хөвсгөл-Органик” бизнес эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөр”-ийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний зардлаас гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010528



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/172

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбооны Бүгд Найрамдах Герман улс руу хүүхэд, эмэгтэйчүүдийн чиглэлээр туршлага судлахад дэмжлэг хүссэн "Эко мами" төрийн бус байгууллагад 1,000,000 (нэг сая), Мөрөн сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үйлчлэх "Шинэ өглөө" төвийн үйл ажиллагаанд дэмжлэг хүссэн тус төвийн менежер Д.Эрдэнэцэцэгт 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671:010544



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/173

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Пауэрлифтингийн нэгдсэн холбооны тамирчин Ц.Отгондалай Америкийн Нэгдсэн Улсын Аустин хотод болох хэвтээ шахалтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 1,000,000 (Нэг сая), Сагсан бөмбөгийн холбооны баг тамирчид Дархан хотод болох U17 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 500,000 (Таван зуун мянга), "Шагайн харваан-2024" аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянга), "Чингүн" боксын клубын баг тамирчид Өмнөговь аймагт болох Өсвөрийн боксын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 500,000 (Таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн) -т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010553



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/180

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн дэмжлэг хүссэн “Сүүн тахилт” төрийн бус байгууллагаас архины хамааралтай иргэдэд сургалт зохион байгуулахад шаардлагатай 3,856.700 (Гурван сая найман зуун тавин зургаан мянга долоон зуун) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 3,856.700 (Гурван сая найман зуун тавин зургаан мянга долоон зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671 010568



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/187

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Төмөрбулаг сумын гэр нь шатсан иргэн А.Ганхуягт 500,000 (Таван зуун мянга) төгрөг, Мөрөн сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг иргэн В.Жавзансүрэнд 500,000 (Таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.
- 2.Дээрх зардлын 1,000,000 (Нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.
- 3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



671?010572



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/102

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн 100 тн тэжээлийн будаа (овьёос) Сэлэнгэ аймгаас татан авах тээврийн зардал, будаа шуудайлах шуудай авах хөрөнгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах нийт 4,850,000 (Дөрвөн сая найман зуун тавин мянга) төгрөгийн зардлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010602

Аймгийн Засаг даргын 20
04 дугаар сарын 24-ны өдрийн захирамжийн хавсралт



НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Тээврийн зардал	Сэлэнгэ аймгаас тэжээлийн будаа татах зардал	3,608,000
2	Будаа шуудайлах шуудай	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	1,242,000
	Дүн		4,850,000

-----oOo-----